

Соёл хоорондын харилцаа ба орчуулга

Н.Нансалмаа /МУИС, ГХСС/

Товч агуулга: *Та бүхэнд танилцуулж буй энэхүү өгүүлэлд дэлхийн олон улс оронд эрчимтэй хөгжиж буй соёл хоорондын харилцааны онолын үүсэл, хөгжил, онолын чиг хандлага, үндсэн асуудлууд, зарим тулгуур нэртомьёог тодорхойлсон бөгөөд орчуулгатай хэрхэн холбогдох тухай өгүүлсэн болно.*

Түлхүүр үг: *соёл хоорондын харилцаа, орчуулга, соёл, харилцаа, соёлын харьяалал, хэлний хамт олны төлөөлөгч, ертөнцийн соёлын зураглал, харилцааны мэдлэг*

Асуудлыг ингэж тавьснаар АНУ болон барууны улс орнуудад өнөөдөр эрчимтэй хөгжиж байгаа СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ОНОЛ гэх харьцангуй залуу салбар ухаан болон энэ салбартай харьцуулахад бие даасан салбар ухаан болж хэдийнэ төлөвшсөн орчуулгазүйн хүрээний асуудлыг зэрэгцүүлэн тавьж уулзах цэгийг тодорхойлох боломжийг хайх оролдлого хийхээр зорилоо.

Соёлын асуудал орчуулгын онол, практикт цаг үргэлж чухал асуудлын нэг байсаар ирсэн ба судлаачдын хандлага харин өөр хоорондоо ялгаатай байж иржээ. Өнөө үед хэл орон судлал, угсаа хэлшинжлэл, соёлын хэлшинжлэл, нийгэм хэлшинжлэл, сэтгэц хэлшинжлэл, орчуулгын онол, танихуйн хэлшинжлэл гэх мэт хэлшинжлэлийн салбар ухааны судлах асуудлын хүрээнд хэл, соёлын харилцан хамаарлын асуудал багтаж хэл судлахад соёлын асуудлыг тооцон зөв зүйтэй тайлбар хийхэд анхаарч байна.

Эдгээрээс бидний сонирхож буй асуудлыг сүүлийн үед “Соёл хоорондын харилцааны онол” болон “Соёлын хэлшинжлэл”-ийн хүрээнд идэвхтэй боловсруулж байна. “Соёл хоорондын харилцааны онол” практик чиг хандлагатай, өөр өөр хэл, соёлын төлөөлөгчид харилцахад соёлын ялгаанаас үүдэлтэй гарч болох саад бэрхшээлийг давж туулахад чиглэсэн бол “Соёлын хэлшинжлэл” онолын чиг хандлагатай, соёл хэлэнд шингэнэ, хэл энэхүү өөрт нь шингэсэн соёлыг илэрхийлнэ, тиймээс хэл судлахад энэхүү соёлын бүрдүүлбэрийг тооцох учиртай гэж үздэг.

Соёлын хэлшинжлэл монгол хэлшинжлэлд нэгэнт нэвтрэн орж ирсэн, хэлний судлагааны янз бүрийн түвшинд хэлний үзэгдлийг хэл, соёлын харилцан хамаарал, шүтэлцээний талаас монгол хэлний баримтаар болон монгол хэлийг өөр бусад хэлтэй зэрэгцүүлэн судлах болсон бол “соёл хоорондын харилцааны онол” манайд шинэлэг байгаа тул энэ салбарын онолын тулгуур асуудал, нэртомьёо, зарчим, хандлагыг тодорхойлох, хэлний салбарын мэргэжилтэн бид өөр холбогдох салбар ухааны төлөөлөгчидтэй хамтран хөгжүүлэх шаардлага нэгэнт бий болжээ.

Хэл, соёлын өөр өөр хамт олны төлөөлөгчдийн олон талт харилцааг **соёл хоорондын харилцаа** (Inter+, cross +, trans+, counter + cultural communication) гэх

нэртөмьёо илэрхийлнэ. Соёл хоорондын харилцаа соёлын антропологи, угсаатан судлал, сэтгэл судлал, угсаа, сэтгэц, нийгэм хэлшинжлэл, харьцуулсан соёл судлал, орчуулгын онол, дадал, бичвэрийн онол зэрэг салбар ухааны судлагааны үр дүнд суурилдаг салбар хоорондын шинжтэй.

Соёл хоорондын харилцааны онол (цаашид СХХО) АНУ-аас үүдэлтэй. 1946 онд АНУ-д “гадаадын улс оронд ажиллах албаны хүрээлэн” (Foreign Service Institute) байгуулагдсан ба хүрээлэнг хүн судлаач, хэлшинжээч Эдвард Холл ахлан, хүн судлал, социолог, сэтгэл судлал, хэлшинжлэл г.м. олон салбарын эрдэмтэд уг хүрээлэнд ажиллах болжээ. Эхэн үед судлаачдын туршлага, мэдрэмжид үндэслэж байсан тул ажил үр дүн багатай байсан тухай энэхүү салбарыг үндэслэгчид тэмдэглэсэн байдаг. Засгийн газрынхан, гадаад улс оронд ажиллах бусад хүн соёл ба харилцааны онолын асуудлыг төдийлөн ойшоохгүй, харин өөр улс оронд ажиллахад хэрэг болох практик зөвлөмж, удирдамж авахыг хүсэж байсан нь гайхал төрүүлж байжээ. Хүрээлэнд улс улсын төлөөлөгчид ажиллаж байсан нь италичууд ярилцахдаа их ойр зогсдог, герегүүд дохио зангаа их хэрэглэдэг, харин хятадууд бараг хэрэглэдэггүй гэх мэтээр харилцаан дахь тэдний соёлын ялгааг олж харахад дөхөм болгох сайн тал байжээ.

Соёл хоорондын харилцааны салбарын төлөөлөгчид америкийн судлаач Э.Холл СХХО-ыг үндэслэсэн гэж хүлээн зөвшөөрдөг ба 1958 онд Э. Холл, Д. Трагир нарын “Соёл харилцаа болох нь” ном хэвлэгдэж “Соёл хоорондын харилцаа” нэртөмьёог анх хэрэглэсэн, 1959 онд Э.Холлын “Чимээгүй хэл” ном хэвлэгдэж энэ номд соёл ба харилцааны холбоог анх үндэслэн “Хэрэв соёлыг судалж болдог л юм бол соёлд сургаж болно” гэсэн дүгнэлт хийсэн зэрэг нь энэ салбар ухааны эхлэл болсон гэж үздэг ажээ. Э.Холлын тодорхойлсноор соёл хоорондын харилцааны онолын гол зорилго нь харилцааг амжилттай болгох үүднээс өөр соёлын төлөөлөгчдийн практик хэрэглээг судлах явдал болно. Ингэснээр соёл хоорондын харилцаа судлахуун болохоос гадна бие даасан салбар байх боломжтой гэсэн дүгнэлт гарлаа гэсэн үг. 1960-аад оноос СХХО-ыг улс хоорондын харилцаа (гадаадад ажиллах мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуульд), үндэстэн, ястан хоорондын (өөр өөр үндэстний хүүхдүүд суралцдаг сургуульд) харилцаа гэсэн үндсэн хоёр чиглэлээр АНУ-ын их дээд сургуульд бие даасан хичээл болгон заах болсон байна. СХХО анх үүсэхэд бий болсон практик хандлага өнөөдөр ч АНУ-ын соёл хоорондын харилцааны асуудалд зориулсан сурах бичгүүдэд гол хандлага болсоор байгаа ажээ.

СХХО удалгүй Европод дэмжигчдээ олох болсон байна. Шинжлэх ухааны олон салбарыг нэгтгэсэн шинэ тутам энэ салбар Германд эрчимтэй хөгжиж 1966 онд Берлин хотноо “өндөр хөгжилтэй ба хөгжиж буй орон хоорондын улс хоорондын ба соёл хоорондын харилцаа” симпозиум болсон бол 1970-аад оноос гадаад хэлний багш нар соёлын харилцан үйлчлэлийн орон судлалын асуудалд хандах болсон, 1989 онд Мюнхений их сургууль “СХХ” шинэ мэргэжил нээсэн ажээ.

СХХО-ыг ОХУ-д санаачлан дэлгэрүүлэгсэд нь Москвагийн их сургуулийн гадаад хэлний багш нар байжээ. Улмаар 1992 оноос соёл хоорондын харилцааг судлах төв байгуулсан ба энд мөн АНУ-ын адил төстэй төвийн зарчмаар хэлшинжээч, түүхч, гүн

ухаанч, уран зохиол судлаач, сэтгэл судлаач, нийгэм судлаач нар ажиллах болов. 1994 оноос тус төв санаачлан “Россия и Запад: диалог культур” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж хурлын эмхтгэлийг цуврал болгон хэвлэх болов. 1993-1994 онд хэл, уран зохиол, соёлыг зэрэгцүүлэн судлах тэнхимүүд байгуулагджээ.

СХХО-г Засгийн газраас дэмжих болсон нь 1996 оны 7 сард ОХУ-ын дээд ба тусгай боловсролын яам №1309 тоот тушаалаар “Гадаад хэл” мэргэжлийг “Хэлшинжлэл ба соёл хоорондын харилцаа” (022600) мэргэжлээр солих шийдвэр гаргаснаас харагдана. Энэ мэргэжлээр суралцаж “Соёл хоорондын харилцааны онол”, “Орчуулга ба орчуулгазүй”, “Гадаад хэл, соёл заах аргазүй” гэж мэргэших боломжтой болжээ. Улмаар 1996 онд энэ салбараар эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулсан, 1997, 1999 онд “Соёл хоорондын харилцаа” хөтөлбөрийн эмхтгэл хэвлэгдсэн нь хэлшинжлэл, түүх, соёл судлал, орон судлал, нийгмийн ухаан зэрэг мэргэжлийн сургалтын хөтөлбөрт туссан байна. Эндээс үзэхэд мэргэжил өөр ч соёл хоорондын харилцаа, төрөлх соёл, уламжлалаа дээдлэх, бусдын соёлд хүндэтгэлтэй хандах хандлагаар бүгд нэгдэнэ. Өнөөдөр ийм замаар явж ирсэн СХХО ОХУ-д нэгэнт бие даасан салбар ухаан болон төлөвшиж ном, сурах бичиг олноор гарч байна.

Үүсэж бий болсноос хойш өнөөдөр олон улс оронд бодит хандлага болсон СХХО өөр өөр хэл соёлын төлөөлөгчдийн бодит харилцаа, уг харилцааны зан үйлийн төрөл болон харилцааны үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг ард түмэн, тэдний доторх төрөл бүрийн давхаргын соёлтой холбон тодорхойлж байна.

СХХО хүн судлал, соёл судлал, социолог, хэлшинжлэл, гадаад хэл заах арга, орчуулгын онол, практикийн асуудлыг тусгасан салбар хоорондын шинжтэй, үр дүн, үйл ажиллагааны чиглэл нь бодит хэрэглээ рүү чиглэсэн хавсрага салбар ухаан болно.

СХХО-ын үндсэн нэгж – дискурсын үйл явц. Өнөөдөр хэлшинжлэлд дискурс гэх нэртомьёо олон утгатай боловч энэ салбар ухаан дискурсын үйл явц гэх нэртомьёогоор харилцааны үр дүн амжилттай болоход чиглэсэн харилцагчдын үгэн ба үгэн бус харилцааны зан үйлийн цогцыг нэрлэдэг. Аль ч ард түмний “мэндчилгээ”, “салах ёс хийх” зэрэг нь СХХО дахь дискурсын наад захын жишээ болно.

Харилцаа амжилттай болох хүчин зүйлийг анхааран судлаж СХХО **соёл, харилцаа, соёлын харьяалал, хэлний хамт олны төлөөлөгч, ертөнцийн соёлын зураглал, харилцааны мэдлэг** гэх ойлголтуудыг үндсэн ойлголтууд хэмээн тодорхойлсон байна.

Соёл нь хүмүүнлэгийн салбарын суурь ойлголт бөгөөд өнөөдөр хэдэн зуугаар тоологдох тодорхойлолт байгаа нь энэ ойлголт өөрөө олон талт, салбар ухаан бүр энэ нэртомьёог өөрийн салбарт чухал гэж үзэх хандлагаар тодорхойлж ирсэнтэй холбоотой юм. СХХО соёл нь хүний амьдралын бүхий л салбар дахь үйл ажиллагааны үр дүнгийн цогц гэж ерөнхийлөн хандаж байна. Ингэснээр өөр өөр хэл, соёлтны харилцаанд гарах олон талт хандлагыг тооцож байгаа байгаа юм гэж ойлгох нь зөв.

Соёл гэх энэ ойлголтыг дагах нэг чухал ойлголт нь **ертөнцийн соёлын зураглал** бөгөөд энэ нэртомьёо өөрийн болон бусдын соёлын үнэт зүйл, хэм хэмжээ, ёс заншил, сэтгэлгээний тухай мэдлэг ба төсөөллийн цогцыг илэрхийлнэ.

Үгэн ба үгэн бус дохиогоор санаа, мэдээлэл солилцох **харилцааны** тухай ойлголт СХХО дахь хоёр дахь чухал ойлголт бөгөөд энэ салбарын судлаачид Р.Якобсон **хэлэхүйн үйл ажиллагааны үндсэн бүрдүүлбэрүүдийг** дараах байдлаар тодорхойлсныг уламжлан дагаж байна (Якобсон):

өгүүлэгч	мэдээллийн агуулга мэдээлэл харилцаа код буюу хэлний хэрэглүүр	сонсогч
----------	--	---------

Тэгвэл энэ тодорхойлолтыг даган харилцааны гадаад нөхцөл ба харилцагчдын сэтгэлийн дотоод байдлын нарийн түвэгтэй нэгдмэл цогцыг нэрлэсэн **харилцааны нөхцөл байдал** гэх ойлголт гарч ирдэг. Харилцааны нөхцөл байдал тодорхой бүтэцтэй ба эдгээр нь харилцааны хувьсагч болно:

- 1) өгүүлэгч
- 2) сонсогч
- 3) тэдгээрийн хоорондын харилцаа, сэтгэл санааны байдал
- 4) харилцааны өнгө (албан, ердийн, найзархаг)
- 5) зорилго
- 6) харилцааны хэрэглүүр, код (хэл, аялгуу, найруулгын төрөл зүйл, дохио)
- 7) харилцах арга (аман / бичгийн, ойр / хол)
- 8) харилцах газар орон
- 9) цаг хугацаа
- 10) сэдэв
- 11) шалтгаан
- 12) үндэстэн.

Эдгээрийн аль нэгийг өөрчлөхөд харилцааны нөхцөл байдал өөрчлөгдөнө.

Соёлын харьяалал гэх ойлголт СХХО-ын үндсэн ойлголтуудын нэг. Хувь хүн өөртөө, бусад хүнд, нийгэмд болон хүн төрөлхтөнд бүхэлд нь хандах үнэт зүйлийн хандлагыг бий болгодог аль нэг соёл, бүлэг соёлд хамаарах байдлыг соёлын харьяалал гэх ба үүний дагуу аль нэг соёлын төлөөлөгч бүх соёлыг “өөрийн соёл”, “бусдын соёл” гэж хуваахад үндэслэнэ.

Хэлний хамт олон – нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын харьцаагаар нэгдсэн, нийгмийн энэ нөхцөл байдалд өдөр тутмын амьдралдаа нэг ба хоёр, хэд хэдэн хэлээр шууд ба шууд бус харилцдаг хүмүүсийн нэгдэл. СХХО –оор **хэлний төлөөлөгч** нь соёлд суурилсан ертөнцийн зураглал ба үнэт зүйлийн тогтолцоог эзэмшсэн, соёл хоорондын харилцаанд орох чадвартай аль нэг үндэстний төлөөлөгч болно. Ю.Н. Карауловын тодорхойлсныг (Караулов, 1989) үндэслэл болговол хүний хэлэхүйн үйл ажиллагааны үндэс болдог тодорхой шинж, чадварын нэгдэл хэлний хамт олон болон түүний төлөөлөгчид шингэсэн байна.

Хэлний төлөөлөгчийн хүйс, нас, яс үндэс, газар орон, анги давхарга, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурьзэрэг нь түүний нийгмийн харьяалал болж харилцаанд нөлөөлдөг.

Хэлний төлөөлөгчийн харилцааны мэдлэг гэх ойлголт СХХО-ын ба нэгэн суурь ойлголт. Америкийн судлаач Делл Хаймс **харилцааны мэдлэг** (communicative competence) гэх нэртомъёог эргэлтэнд оруулсан (Hymes, 1972) ба хэлзүй ба хэрэглээ эзэмших нь харилцааны мэдлэгийн бүрдүүлбэр хэсгүүд болох ба хэл эзэмших нь цэвэр хэлшинжлэлийн бус нийгэм хэлшинжлэлийн үзэгдэл болно гэж дүгнэжээ. Мөн У. Лабов, С. Эрвин-Трипп нар ч хүний хэл ярианы чадварыг нийгмийн хүчин зүйлтэй холбон судлах учиртай тухай өгүүлж байв. Харилцаа амжилттай болохын тулд харилцагчид тухайн хэлний үгийн сан, тэдгээрийг холбох дүрэм буюу хэлзүйг мэдэхээс гадна **“нөхцөл байдлын хэлзүй”** - г мэдэх шаардлагатай тухай судлаачид тэмдэглэжээ (Беликов, Крысин, 2001).

Харилцааны мэдлэгт харилцааны хэм хэмжээ (оросоор ярихадхэнд та, хэнд чи гэж хандах, англи хэлний you гэх үгийг хэзээ та, хэзээ чи гэж орчуулах, япон, солонгос хэлний үйл үгийн олон төрлийн эелдэг хэлбэр, мөн үйл үгийн адил төстэй утга илэрхийлэх олон хэлбэрийн аль нь эелдэг, аль нь тушаасан хэлбэр болох г.м.), томчууд ба хүүхдийн харилцааны хэм хэмжээ, “өөрийн ба хүний хүн” гэх ойлголт, нийгмийн байдал “дарга, захирагдагч, эн тэнцүү”, багш, оюутан, “нийгмийн харилцааны зай” барих дүрэм, харилцааны зан үйлийн төрөл бүрийн стратеги, арга (гуйх, хүсэх, шаардах, буруутгах, заналхийлэх, амлах г.м) гэх мэт ойлголтоор тодорхойлогдоно.

Эдгээр дүрмийн ихэнхийг “бичээгүй”, “нөхцөл байдлын хэлзүй” зохиогоогүй. Гэвч хэлний хамт олны ихэнх нь эдгээр дүрмийг мэддэг, дагаж мөрддөг. Ер нь гэр бүл мэт бичил хамт олноос энэ төрлийн “дүрэм”-д суралцдаг. Өөрийн хэлийг сурахын хамт өөрийн хэл, соёлд хамаарах “нөхцөл байдлын хэлзүй”-д суралцан соёлжиж, гадаад хэл сурахад мөн тэр хэл, соёлд дагаж мөрддөг “нөхцөл байдлын хэлзүй”-д суралцах шаардлагатай.

Тэгвэл хэл буюу код мэдэхгүй байх, хэлний бус, тэмдгийн тогтолцоо (жнь, дохионы хэл) мэдэхгүй байхаас гадна энэ дүрэмд суралцаагүйгээс харилцаа амжилтгүй болох талтай.

Соёл хоорондын харилцааны онолыг ийнхүү тодорхойлсны дараа орчуулгатай хэрхэн холбогдох тухайд анхаарал хандуулъя. Орчуулга соёл хоорондын харилцааны салшгүй нэг хэсэг. Харилцагчид өөр өөр соёлын төлөөлөгчид болохын зэрэгцээ өөр өөр хэлний, эсвэл нэг хэлний өөр өөр хувилбарын төлөөлөгчид байна. Тиймээс харилцаа хэлний тэмдгийн өөр өөр тогтолцоо буюу өөр өөр хэлний хэрэглүүрийн тусламжтай болно. Ийм төрлийн харилцааг орчуулгагүйгээр төсөөлөх аргагүй.

Мөн өөр хэл, соёлтны хооронд харилцаа болохоос гадна хэлний тэмдгийн нэг тогтолцооны өөр өөр хувилбар буюу код эзэмшигчдийн хооронд харилцаа болох ба тэдний харилцаанд хэлээр нэгдсэн ч нийгмийн харьяалалаас хамаарах соёлын өөр өөр зураглал байна. Эндээс үзэхэд соёл хоорондын харилцаа зөвхөн өөр хэлтэн ард түмний төлөөлөгчдийн хооронд болох зүйл гэж үзэх нь өрөөсгөл хандлага юм. Нэг хэлний хамт олны төлөөлөгчид болох ч чухам энэ нийгмийн харьяалалаас үүдэх хүчин зүйлээс хамаарч харилцаа амжилтгүй болдгийг бид өөрсдийн хэлний хамт олон доторх өдөр тутмын амьдралын жишээнээс мэдэх билээ.

Соёл хоорондын харилцаа шинжлэх ухааны салбар болохын хувьд олон соёлыг харьцуулан судладаггүй, харин соёл хоорондын үгэн ба үгэн бус харилцаанд үүсэх үзэгдлийг соёлд суурилан тайлбарлана. Гадны судлаачдын бүтээлд тааралдах cultural translation нэртомьёог соёлын орчуулга гэж шууд үгчлэн орчуулж хэрэглэх нь соёл, орчуулга гэх хоёр үгийн утгад нийлэмж үүсгэх боломж олгох нийтлэг утгын бүрдүүлбэр байхгүй тул монгол хэлэнд зөв нийлэмж үүсэхгүй, өөрөөр хэлбэл, соёлыг орчуулж болохгүй, тайлбарлаж болно. Иймээс энэ үзэгдлийг орчуулгатай холбоно**орчуулга дахь соёл хоорондын харилцааны асуудал**, эсвэл **соёл хоорондын орчуулга** гэж нэрлэх нь тухайн үзэгдлийн мөн чанарыг бодолцсон нэрлэлт болох юм гэж үзэж байна.

Дэлхий нийтээр өөр бусад улс оронтой нээлттэй харилцах болсон өнөө үед нийгмийн амьдралын бүхий л салбарт шингэсэн өөр өөрийн өвөрмөц соёлтой ард түмнүүдийн соёл хоорондын харилцааны асуудал нэн чухал бөгөөд өөр хэлтэн харилцаж л байгаа бол өөр өөр соёлын харилцаа болж байна л гэсэн үг билээ. Улс оронд олон гадаад хэл судлах болсон, цахим сүлжээгээр гүүр хийж олон улс оронтой харилцах боломжтой болсон зэрэг хүчин зүйл аливаа гадаад хэл сурах, хэлээр нь дамжуулан уг хэлээр хэлэлцэгч ард түмний соёлыг нь ойлгох асуудлыг улам бүр эрчимжүүлж байна. Бид бүхний эрхэлдэг үндсэн ажил болох гадаад хэлний бүх хичээл соёл хоорондын харилцааны жишээ, мөн соёл хоорондын орчуулгын жишээ болно. Цаашлаад бүх төрлийн бичвэрийн орчуулга болон шууд аман орчуулга соёл хоорондын орчуулга билээ.

Өөр хэл, соёлын төлөөлөгчдийн харилцаа бүр соёл хоорондын харилцаа ба орчуулга уулзах цэг болон задрах ч нийтлэг зарим зүйлийг нэгтгэх оролдлого хийе.

1. СХХ-ны суурь ойлголт нь **хэл, соёлын харилцан хамаарал, шүтэлцээний асуудал** юм. Хэл, соёлын харилцан хамаарал, шүтэлцээний асуудлыг Хумбольдтоос эхлээд олон орны олон эрдэмтэн боловсруулж ирсэн ба орчуулгын онол, практиктай орчуулагдах, эс орчуулагдах тухай орчуулгын дүйцлийн асуудлаар холбогдоно.

2. Хэлний нэгжээр илрэх **суурь мэдлэгийн асуудлаар** холбогдоно. Хэлийг нь судлаж буй улс орны ахуй, соёл, түүх, уламжлал, ёс заншилтай холбоотой баримт зэрэг хэл, сэтгэлгээ, соёлын онцлог болох энэ суурь мэдлэгийг нөгөө хэлтэнд хэрхэн дамжуулах асуудал. Мөн тухайн хэл, соёлтонд хамаарах биеийн хэл, харилцааны зан үйл ч суурь мэдлэгт орно.

3. **Ертөнцийн хэлний зураглал ба ертөнцийн соёлын зураглалын харилцан хамаарал**. Ертөнцийн хэлний зураглал нь хэлэнд шингэн хадгалагдаж, хэлний

тусламжтайгаар үеэс үеэд дамжихертөнцийн тухай мэдлэгийн цогц бол СХХО –ын төлөөлөгчдийн үзэж байгаагаар **ертөнцийн соёлын зураглал нь** өөрийн ба бусдын соёлын үнэт зүйлс, хэм хэмжээ, зан үйл, сэтгэлгээний тухай мэдлэг, төсөөллийн цогц (Тер –Минасова, 2000, Садохин, 2005) болно. Ертөнцийн соёлын зураглал бодит ертөнцийг “мэдрэмжийн эрхтнээр дамжин ухамсарт шингэсэн ойлголтуудаар” шүүнэ.

СХХО-д “ертөнцийн нэгдүгээр зураглал” (төрөлх), “ертөнцийн хоёрдугаар зураглал” (гадаад хэл сурахтай хамт бий болсон) гэсэн хоёр зүйл ертөнцийн зураглалыг ялгаж үздэг. Өөрийн ертөнцийн зураглалд дассан харилцагчид ертөнцийг өөрөөр харж ойлгох, хүлээж авах, суралцах шаардлага гардаг, төрөлх соёлын нөлөөнд ордог нарийн үйл юм. Орчуулгад үндэсний соёлын ялгаанаас үүдэлтэй бэрхшээл гарах тухай “хэл-үндэстний саад” гэх ойлголт байна. Энэ ойлголтод харилцааны гадаад хүчин зүйл бус, харин харилцааны мэдлэг, үзэл бодол, итгэл үнэмшил, сонирхол, хандлага, үнэлэмж зэрэг дотоод хүчин зүйл чухал үүрэгтэй ажээ.

Орчуулга хийхэд нэг хэлний тэмдэгт нөгөө хэлний тэмдгийг зүгээр нэг оноож өгч байгаа хэрэг биш, уг тэмдгийг тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний бодит амьдралыг тусгасан “код” хэмээн үзэж агуулгыг зөв дамжуулах нь чухал. Энэ агуулгыг “соёл” юм гэж үзвэл орчуулагч соёл хоорондын орчуулга хийж буй хэрэг. Орчуулгын чанар “өөрийн” болон “бусдын” соёлыг хэрхэн ойлгосноос хамаарна. “Өөрийн” ба “хүний” гэсэн хоёр өөр хэл, соёлын уулзвар дээр байдаг орчуулагчид аль соёлын ертөнцийн зураглал чухал вэ? Нэгдүгээр үү?Хоёрдугааруу? Энэ тухайд харилцааны янз бүрийн нөхцөл байдалд бичвэрийн болон аман ярианы төрөл зүйл, сэдвээс хамааран өөр өөрөөр хариулж болох талтай гэж үзэж болох ч оновчтой зөв хариулт өгөхийн тулд нарийвлан судлах, ажиглах шаардлагатай. Тухайлбал, албан бичгийн орчуулгад **хоёрдугаар хэлэнд шингэсэн соёл** чухал буюузориулан захидал бичиж байгаа тэр хүнийхэлний албан бичгийн хэм хэмжээ, тогтсон үг хэллэгийг барина. Харин уран зохиолын орчуулгад аль соёлын зураглалыг чухалчилж үзэх вэ? Энэ талаар орчуулгын онолд олон санал гарч байсан ба одоо ч СХХО-ын төлөөлөгчид өөрсдийн дэвшүүлсэн онолын үүднээс санал солилцон уг асуудлыг боловсруулж байна.

Орчуулахад зөвхөн хэлийг анхаарах бус нөгөө хэлний тэмдгээр соёлыг хэрхэн дамжуулахад анхаарах учиртай. Энэ нь орчуулагч тухайн хэлэнд шингэсэн соёл, тухайн хэлтнийг илэрхийлэх соёлыг мэдэх шаардлагатай гэсэн үг юм.

Ямар төрлийн мэдээлэл байгаа болон хэлийг хэрхэн ашиглахаас хамаарч

- Хэлний тэмдгийн тогтолцоог эзэмших түвшин
- Үндэсний соёлын түвшин
- Нэвтэрхий толины түвшин
- Нөхцөл байдлын түвшингэж ялгах ба задалж үзвэл:

Хэлний түвшин:

- санааг хэлний төрөл бүрийн хэрэглүүрээр илэрхийлж чадах: нэг санааг олон янзаар хэлэх

- хэлсэн зүйлээс санааг ялгаж ойлгох чадвар: үгийн олон утга, ойролцоо утга
- зөв хэрэглээг буруугаас ялгаж чадах: хэрхэн ярих зөв, буруу болохыг мэдэх

Үндэсний соёлын түвшин:

Хүн багаасаа хэл эзэмшихийн хамт соёлд суралцдаг. Энэ соёл хэлний хэрэглүүрийг ашиглахтай холбоотой. Жишээ нь, Монголд цай чанадаг бол Оросод хандлана. Цай чанах гэж ярих нь тэдний хувьд ер бусын хэрэглээ болно. Финляндад өндөг ширхэгээр бус хилээр нь зардаг тул дэлгүүрт ширхэг өндөг өгөөч гэх нь буруу хэрэглээ. Ийм ялгаа нэг хэлний хамт олны нийгмийн өөр өөр бүлэгт ч бий.

Үндэсний соёлын түвшин нь үндэсний онцлог бүхий соёлын бүрдүүлбэрийн тухай ойлголт болох ба Тер-Минасова дараах байдлаар задлажээ:

- а) уламжлал, ёс заншил, зан үйл;
- б) ахуйн соёл;
- в) өдөр тутмын зан үйл (дасал болсон зан үйл), эдгээртэй холбоотой дохио зангаа, биеийн хэл;
- г) “ертөнцийн үндэсний зураглал”, сэтгэлгээний онцлог;
- д) үндэстний уран сайхны соёл (Тер-Минасова, 2001, 28).

Энэ судлаачийн саналыг дэмжиж, дэлгэрүүлж буй өөр нэг саналыг ишлэл болгоё:

“Тухайн хэл, соёлын төлөөлөгч мөн онцлог шинж төлөвтэй. Соёл хоорондын харилцаанд харилцагчдын үндэсний зан төлөв, хандлага, сэтгэл хөдлөлийн онцлог, сэтгэлгээний онцлогийг тооцох учиртай” (Антипов нар,1989, с. 77).

Нэвтэрхий толины түвшин:

- “Үгийн ертөнцийн” мэдлэг, энэ мэдлэг хүн төрөлхтний нийтлэг шинжтэй байхаас гадна, үндэсний шинж бас агуулна. Үгийн ертөнцийн мэдлэг нь хэлний аль нэг тэмдэгт бэхлэгдсэн цогц ойлголт юм.
- Логик харьцаа: учир шалтгаан, цаг хугацаа, орон зай, төрөл зүйлийн холбоо, харьцаа.

Нөхцөл байдлын түвшин:

- Харилцааны хэлзүй, стратеги, арга, хандлага, мэдрэмж болно.

Эдгээрийг соёл хоорондын харилцаа, тэр дундаа түүний нэгэн төрөл болох орчуулгад хамааруулан дараах байдлаар бүдүүвчилж харъя.

Төрөлх хэл	<ul style="list-style-type: none"> • Гадаад хэл
<ul style="list-style-type: none"> • Хэлний тэмдгийн тогтолцоог эзэмших түвшин • Үндэсний соёлын түвшин • Нэвтэрхий толины түвшин • Нөхцөл байдлын түвшин 	<ul style="list-style-type: none"> • Хэлний тэмдгийн тогтолцоог эзэмших түвшин • Үндэсний соёлын түвшин • Нэвтэрхий толины түвшин • Нөхцөл байдлын түвшин

Өөр хэл, соёлтны харилцаа, орчуулгад энэ багц ойлголт зэрэгцэн орших ба эдгээр түвшинг хэрхэн эзэмшсэн, хэрхэн хэрэгжүүлэхээс харилцаа амжилттай болох, орчуулга сайн болох нь шалтгаална.

“Хувь хүн, хэсэг бүлэг хүн, ард түмэнд танин мэдэх болон сэтгэл хөдлөл талаас чухал, өмнөх үе болон түүний одоогийн хүрээлэлд сайн танил, жишиг болгон байнга ханддаг юм, үзэгдэл, хүн” -ийг СХХО чухалчилж **precedent phenomena** гэж нэрлэж байгаа нь бидний дөнгөж сая тодорхойлсон хэл эзэмшихтэй холбоотой, орчуулгад гарах соёлын бэрхшээл байнга тулгардаг, соёл хоорондын орчуулгад анхааран судлах зүйл юм. Соёлын ийм төрлийн мэдээлэл аливаа хэлний тогтвортой нийлэмж, онигоо, уран зохиолын бичвэр, ардын аман зохиол, кино, телевизийн шоу төслүүд, улс төрчид, нэрд гарсан хүмүүсийн нэр, зарлал, реклам гэх мэтэд нэн элбэг. Иймээс эдгээр төрөл соёл хоорондын харилцаа, орчуулгад зөв ойлгох, харилцаа амжилттай болохын тулд харилцагчдаас суурь мэдлэг шаарддаг онцгой төрөл болно.

В.В. Красных: “бусдын” соёл хэзээ ч “өөрийн” соёл болохгүй, харин тэдний дунд “өөрийн” болох нь сонирхолтой боловч аюултай байж болох, шинийг нээхийг амладаг ч болгоомжтой байхыг шаарддаг, сэтгэл ханамж авдаг ч өөрийнхөө тухай бодоход хүргэдэг соёл хоорондын харилцааны замд орж буй хүнд боломжтой зүйл” гэж тэмдэглэсэн нь бидний энд дэвшүүлэн хэлэлцсэн асуудлын дүгнэлт болох боломжтой.

Номзүй

Антипов Г. А, Донских О. А, Марковина И. Ю, Сорокин Ю. А. Текст как явление культуры. Новосибирск, 1989, с. 75.

Беликов В.И., Крысин Л.П. Социоллингвистика Учебник для вузов Изд. Рос. гос. гуманит. ун-та Москва, 2001, 439с.

Бюллетень Государственного комитета Российской Федерации по высшему образованию № 9, 1996 год

Караулов Ю.Н. Русская языковая личность и задачи её изучения //Язык и личность. М.,1989. – С.3-8.

Лабов Уильям. Исследование языка в его социальном контексте. // Новое в лингвистике вып. VII Социоллингвистика изд.«Прогресс» Москва 1975,с. 96-182

Лабов Уильям. Отражение социальных процессов в языковых структурах. // Новое в лингвистике вып. VII Социоллингвистика изд.«Прогресс» Москва 1975,с. 320-336

Мунэн Ж. Теоретические проблемы перевода. Перевод как языковой контакт// Вопросы теории перевода в зарубежной лингвистике 1978, 36

Найда Юджин А. К науке переводить. Принципы соответствий //Лингвистические аспекты теории перевода (хрестоматия). –Ер.: Лингва, 2007. с.4-32

Садохин А.П. Межкультурная коммуникация: Учебное пособие. М.: Альфа-М; ИНФРА-М, 2004. - 288 с.

Тер-Минасова С. Г. Язык и межкультурная коммуникация: (Учеб. пособие) — М.: Слово/Slovo, 2000. — 259с.

Хаймс Делл Х. Этнография речи. //Новое в лингвистике вып. VII Социоллингвистика изд.«Прогресс» Москва 1975,с. 42-96

С. М. Эрвин-Трипп. Язык. Тема. Слушатель. Анализ взаимодействия. // Новое в лингвистике вып. VII Социоллингвистика изд.«Прогресс» Москва 1975,с. 336-363

Якобсон Р. О лингвистических аспектах перевода// Вопросы теории перевода в зарубежной лингвистике1978, 16